

“ШАР СОНИН” САЙН ХЭВЛЭЛ БОЛОХ НЬ

Г.Өнөрбаяр*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, магистр, докторант

Түлхүүр үг: “Шар хэвлэл”-ийн үүсэл хөгжил, нэр томьёо, “Шар хэвлэл”-ийн төлөөх тэмцэл, сонины менежмент, маркетинг Ж.Пулицер, У.Хёрстийн өрсөлдөөн.

Э. Бат-Үүл 1996 оны “Шилдэг улс төрч”-өөр шалгараад “Шар хэвлэлийг “устгах” миний төлөвлөгөө” хэмээх лекц уншиж олныг шуугиулж байлаа. Уг илтгэлдээ “Шар хэвлэл”-ийг “устгах” биш чөлөөт хэвлэлийг “хамгаалах” гэсэн байр сууриа ийм сүржин нэрийн дор илэрхийлж, сэтгүүл зүйн хөгжлийн төлөө өөрийн үзэл санаагаа нэмэрлэснийг тодхон санаж байна. Харин би энэ удаа он удаан жилийн турш манай сэтгүүл зүйн салбарт тун тааруу үнэлэмжээр үнэлэгдсэн “Шар сонин” сайн хэвлэл болохыг баримт нотолгоогоор батлана.

“Шар сонин” хэмээх ойлголт дэлхийн сэтгүүл зүйн салбарт орж ирээд 113 жилийн нүүрийг үзлээ. Харин энэ нэр томьёо манай сэтгүүл зүйн салбарт 16 жилийн өмнөөс эхэлсэн нийгмийн

өөрчлөлт шинэчлэлт, ардчилал, эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрхтэй хамт орж ирсэн юм. Энэ 16 жилийн турш бид чөлөөт хэвлэлийг “Шар сонин” хэмээн нэрлэж, нийгмийн хамгийн бузар булай зүйл мэтээр ойлгон сурталчилж, тэнд ажилладаг сэтгүүлчдийг хамгийн ёс зүйгүй нөхдийн дүрээр харуулж, сэтгүүл зүйн нэр хүндийг дэндүү доогуур үнлэсэн нийгмийн үнэлэмжийг бий болгоод зогсохгүй хэвлэлийг шар, хараар нь ангилан цоллож ирлээ. Дэлхийн сэтгүүл зүйд манайх шиг хэвлэлийг, шар хараар нь ангилдаггүй. Харин өмчлөлийн байдлаас нь шалтгаалан төрийн, хувийн, олон нийтийн гэж ангилдаг. Эсвэл эрх зүйн байдлынх нь хувьд чөлөөт, төрийн гэж хуваах нь ч бий. Манайхан хэвлэлийг хар, шар хэмээн хаана ч байдаггүй өнгө, будагийн хослолоор ангилж мэргэжлийн нэр хүндийг маань унагах боллоо. Үүнийг дагаад нийгмийн сэтгэл зүйд сэтгүүлчийн мэргэжил, чөлөөт хэвлэл гэсэн ойлголтууд ч үнэлэгдэхээ байх нь. Улиг болж мэдэх энэ доромжлол, сайн хэвлэлийг муу

хэмээн гүтгэсэн улс төрчдийн явуулга, мэргэжлийн нэр хүндээ өмгөөлж чадахгүй байгаа үзэг нэгтнүүдийнхээ дасан зохицож буй энэ байдлаас би татгалзаж байна. Харин би чөлөөт хэвлэлийг "Шар сонин" гэсэн улиг болсон энэ ойлголтоос огт өөр өнцөгөөс тайлбарлахыг хүсэж байна.

Юуны өмнө "Шар хэвлэл", "Шар сонин", "Шар сэтгүүл зүй" гэсэн эдгээр ойлголтуудыг гарал үүслийн хувьд авч үзэн тодорхой болгох ёстой. Сэтгүүл зүйн судлаач доктор М. Зулькафиль "Дуулиан шуугиан, адал явдал, хов живийн шинжтэй мэдээллийн араас хэт хөөцөлдөж, уншигчдын сэтгэл зүйгээр тоглох замаар зөвхөн ашиг орлогоо боддог

сонин хэвлэлийг дэлхийн сэтгүүл зүйн практикт "шар хэвлэл" гэж нэрлэдэг"¹ хэмээн тайлбарласан. Харин Э.Бат-Үүл "зохиох, гүтгэх зэргээр сенсаци үйлдвэрлэх явдлыг шар сэтгүүл зүй хэмээдэг"² гэж тодорхойлсон юм. Энэ мэтээр муу "Шар хэвлэл" гэсэн ойлголт нь нийгэмд бат бөх оршсоор ирсэн нь ингэж тодорхойлоход хүргэжээ. Ерөнхийдөө манайхан зохиодог, гүтгэдэг хэвлэлүүдийг "Шар хэвлэл" хэмээн тайлбарлан ойлгож иржээ. Энэ ойлголт ч манай сэтгүүл зүйн салбарт нэгэнт идээшин дасчээ. Өнгө будаг талаас нь

биш үүсэл гаралынх нь хувьд мөшгөн үзвэл "Шар сонин" гэсэн энэ нэр бидний бодож тайлбарладаг шиг тийм бузар булай зүйл бишээ. Харин ч сайн хэвлэлийг хэлсэн нэр томъёолол болно. Анхны "Шар хүүхэд"-ийн цувралыг эхлүүлсэн "The New York World" төдийгүй ихэнх сонинууд тухайн үед гар зурагтайгаар хэвлэгдэн гарч байлаа. Харин Ж.Пулицер олны танил хүмүүсийг

элэглэсэн шог хошин зургуудыг түлхүү нийтэлж байв. Тиймээс "The New York World"-ийн дугаар бүрийн нэгдүгээр нүүрний баруун, зүүн дээд буланд улс төрч, баячууд, гэмт хэрэгтэн гэх мэт олон нийтийн анхаарлыг татсан хүмүүсийн хөрөг зургийг нийтэлж нийгмийнхээ дүр зургийг гаргахыг зорьсон юм. Энэ нь "Шар хүүхэд"-ийн цуврал зураг үүсэх шалтгаан болсон.

1893 онд "The New York World" сонинд анхны өнгөт зураг нийтлэгдэв. Энэхүү өнгөт зураг нь Хоугэнс Элли хэмээх хороололын (гудамж) хүүхдүүдийн хамгийн жижигийг нь өхөөрдөж зурсан зураг байв. Зарим судлаачид үүнийг "Хоугэн Элли хорооллын бяцхан хулигаануудын ахлагч жаалыг зураач Ричард Ауткот тод шар цамцтай зурсан нь хожим «шар хэвлэл» («Yellow Press»)

хэмээх нэр томъёо үүсэхэд нөлөөлжээ”³ хэмээн дүгнэсэн байдаг. Хоугэнс Элли хорооллын хүүхдүүдийн ахлагчийг биш харин тэднийг өхөөрдөж хамгийн жижигийг үлгэрийн байдлаар зурсан нь олон нийтийн анхаарлыг татах шалтгаан болсон юм. Уг хүүхдийг нийгмийн бүхий л үйл явдалд оролцож буй байдлаар Р.Ауткаулт зурав. “Хоугэнс Эллигийн бэйсболийн багийн аврага шалгаруулах анхны тэмцээн”⁴, “Хоугэнс Эллигийн өмнөд”⁵, “Хоугэнс Эллид тоглосон шилдэг спортуудын нэг нь гольф”⁶, “Хоугэнс Элли дэх циркт”⁷, “Хоугэнс Эллигийнхэн нүүж байна”⁸, “Хоугэнс Эллигийнхэн хуралд бэлтгэж байна”⁹, “Хоугэнс Эллид улирлын уралдаан эхэллээ”¹⁰, “Хоугэнс Эллигийн улирлын анхны нэгдсэн жагсаал”¹¹, “Төв паркад Хоугэнс Эллигийн энгийн иргэд завь хөвүүлж байна”¹², “Хоугэнс Эллигийн энгийн л нэг өдөр. Долоон сарын дөрвөн”¹³, “Хоугэнс Элли дэх улс төрийн халуухан цуглаан”¹⁴, “Хоугэнс Эллигийн хүүхдүүд бүтэн өдрийг хөдөө өнгөрүүлэв”¹⁵, “Хоугэнс Эллигийн дээвэр дээрх цэцэрлэгийн нээлт”¹⁶ зэрэг үйл явдлуудаас эхлээд “Шар хүүхэд ба түүний шинэ эгшигт хайрцаг”¹⁷, “Шар хүүхэд үсний өнгө сэргээгч бэлдмэлийг туршиж үзлээ”¹⁸ гэх мэтээр “Шар хүүхэд”-ийг бараа бүтээгдэхүүний сурталчилгааны гол дүрээр харуулсан юм.

Энэ нь хүмүүст таалагдаж, шар хүүхдийг өхөөрдөх хандлага бий болж. Улмаар Ж.Пулицерийн сонин олон мянган хувиар борлогдож эхэлсэн нь

өрсөлдөгч У.Хёрстад таалагдсангүй. Уур бухимдлаа барьж ядсан У.Хёрст өөрийнх нь сониноос илүү олон хувиар борлогдох болсон Ж.Пулицерийн “The New York World”-д атаархаж “муу шар хэвлэл” хэмээн хараан зүхээд зогсохгүй уг цувралыг хөтөлж байсан зураач Р.Ауткаултад өндөр цалин амлаж өөрийн сониндоо ажиллуулж дөнгөв. Р.Ауткаулт У.Хёрстийн “The Morning Journal”-д шар хүүхдийн цувралаа үргэлжлүүлэн хөтөлсөн юм. Энэхүү шар хүүхдийн цуврал зураг, хэвлэлийн хаан У.Хёрстын “Муу сайн шар хэвлэл” гэсэн хараал зүхлийн үгнээс л “Шар сонин” хэмээх нэр томъёо үүсжээ. Өөрөөр хэлбэл “Шар хэвлэл” гэсэн үг нь өөрийн өрсөлдөгчийнхөө сониныг “магтаж муулсан” сэтгүүлчийн амнаас анх гарсан үг болно. Тэгэхээр “Шар хэвлэл” гэсэн үг нь атаархалаас үүдэлтэй, муу биш сайн сониныг хэлсэн томъёололоос гадна олон түмний анх өгсөн үнэлэмж биш ажээ.

“Шар хүүхэд”-ийг эхлээд нийгмийн бүхий л үйл явдалд оролцуулсан байдлаар зурав. Тэр нь нийгэмд өрнөж буй болж бүтэхгүй зүйлүүдээс гадна хөгтэй, хөөртэй, эмгэнэлтэй үйл явдлуудаар баяжигдаж байлаа. “Шар хүүхэд” олон нийтэд ихээхэн таалагдсан учир томоохон цуврал ажиллагаа болж өргөжсөн юм. Энэхүү цуврал зургуудад нийгмийнхээ амьдралыг тусгахаас гадна төр засгийн бодлого, иргэдийн байр суурийг товойлгон харуулаад зогсохгүй нөлөө бүхий хүмүүсийн дүрийг ч үйл

явдлын дунд шоглон үзүүлэв. "Шар хүүхэд"-ийн цуврал зургуудад муур, шувуу, ямаа гурав үргэлж онцгой үүрэг гүйцэтгэж байлаа. Энэ гурван амьтан бол "Шар хүүхэд"-ийн зургийг товойлгож харуулахад зориулагдсан туслах дүрүүд болно. "Шар хүүхэд"-ийн цуврал нь ихээхэн амжилт олсон учир сониноо сурталчлах дүр болгоод зогсохгүй бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор сурталчилгаанд ашигласан юм. "Шар хүүхэд" өргөн хэрэглээний хүнсний бараа бүтээгдэхүүнээс эхлээд гоо сайханы зүйлсийн гол дүр болж хувирсан юм. "Шар хүүхэд"-тэй бүхэний борлуулалт зах зээлийг хошууруулж байлаа. Үлгэр, домгийн хэлбэрээр илэрхийлэгдсэн шар хүүхдийг олон нийт ихээхэн өхөөрдөх хандлага ч улам нэмэгдэв. Үүнийг дагаад "Шар хүүхэд"-ийн зурагтай бараа бүтээгдэхүүн ч зах зээл дээр амжилт олсон юм. Улмаар шар өнгөтэй бараа бүтээгдэхүүн зах зээлд ихээр борлогдож энэ өнгө Америк маягийн амьдралыг илтгэн харуулах болжээ. "Шар хүүхэд" ч үндэсний бахархалын хэмжээний билэг тэмдэг болж хүрээгээ тэлэв. "Шар хүүхэд"-ийн зурагтай бэлэг дурсгалын зүйлс ихээр гарав. "Шар хүүхэд"-ийн зурагтай энгэрийн тэмдэгээр хүн бүр гангарч, "Шар хүүхэд"-ийн зурагтай янжуур татаж, "Шар хүүхэд"-ийн зурагтай хүнсний бүтээгдэхүүн хэрэглэж, "Шар хүүхэд"-ийн зурагтай аяганаас хооллож, "Шар хүүхэд"-ийн зурагтай хөзрөөр зугаагаа гаргаж, "Шар хүүхэд"-ийн хунлитай захидал бие

биедээ илгээж, "Шар хүүхэд"-ийн зурагтай маркийг чухалчилж, "Шар хүүхэд"-ийн зурагтай ном уншиж, "Шар хүүхэд"-ийн зурагтай хувцасаар гангарч "Шар хүүхэд"-ээр Америкийн нийгэм өвчилж байлаа. Эцэст нь "Шар хүүхэд"-ийн тухай дуу, шүлэг зохиогдож домог болон мөнхөрсөн юм. Шар цүнх, гутал, цамц, футболк, сонин гээд Америкийн зах зээлийг шар өнгө "галзууруулав". Бас "Шар хүүхэд"-ийн зурагтай комикс ном хэвлэгдэж нэг бүр нь 50 сентээр үнэлэгдэн бестселлер болж олныг хошууруулав. Хүн бүр л "Шар хүүхэд"-ийг өхөөрдөж, хүүхэд бүр л "Шар хүүхэд" шиг баатар болохыг мөрөөдөж, хүн бүр л үр хүүхдээ "Шар хүүхэд" шиг алдаршихыг ерөөж байлаа. Ийм нийгмийн хөөрөлийн үед хэвлэлийн магнат У.Хёрст өөрийн сониныхоо захиалагч бүрт "Шар хүүхэд"-ийн зурагтай энгэрийн тэмдэгийг бэлэглэж сониноо сурталчилж байв. Энэ бүхнийг дагаад тухайн үед Ж.Пулицер, У.Хёрстийн сонинууд алдаршиж, нэр хүнд нь өсч байлаа. Бас "Шар хүүхэд" үндэсний хэмжээний бэлэг тэмдэг болож хувирахын хирээр хэвлэлийн магнатууд "Шар хүүхэд"-ийнхээ төлөө мэдээллийн дайныг дэгдээсэн юм. Хэн нь "Шар хүүхэд"-ээ өмчилөх вэ гэдгээс үүдсэн энэ дайн эцэстээ У.Хёрстынхоор төгсөв. У.Хёрст сэтгүүл зүйд хөл тавьсан цагаасаа эхлэн Ф.Пулицерийн арга барилыг сонирхон судалж түүнтэй өрсөлдөхийг туйлаас хүсч байв. Тиймээс түүний сайн сэтгүүлчдийг өндөр цалин амлан өөрийн сониндоо урвуулж,

менежментийнх нь арга · барилыг хулгайлж, яг адилхан нийтлэлийн бодлого баримталж, сониных нь макет дизайн, булангуудыг хуулбарлах зэргээр анхны хэвлэлийн хааныг амар заяа үзүүлээгүй юм. Ж.Пулицерийн "The New York World" сониных нь эсрэг "The Morninng Journal"-аа, амралтын "The Sunday World" сонинтой нь "The Sunday Journal"-аа өрсөлдүүлэх болов. Нэг үе эдгээр сонинуудын нүүрнийнх нь тоо, макет дизайн, хэл найруулга нь андуурам адилхан байлаа.

Ерөнхийдөө "Шар хүүхэд" бол тухайн үеийн хорооллын жаалуудын билэгдлийн дүр боловч сониноо сурталчилах, нийгмийн үйл явдлуудыг хөг хэмнэл дунд нь харуулах, бараа бүтээгдэхүүнүүдийг борлуулах, шинэ зах зээл үүсгэхэд зориулсан цуврал пиар ажиллагаа байв. Нөгөө талаараа "Шар хүүхэд" бол Mickey Mouse, Tom, Jerry гэх мэт дүрүүдтэй эн тэнцүү хэмжээнд дүйж очих үлгэрийн дүр болж эцэстээ Америкийн сэтгүүл зүйн төдийгүй нийгмийн үйл явдлын томоохон гэрч төдийгүй домогийн хэлбэрээр түгсэн ажээ.

Яваандаа хэвлэлүүд улс төрчид, урлагийн оддын бузар булхайг үнэн бодитойгоор бичих болсонд тэд атаархаж "Шар хэвлэл" гэсэн нэр томъёог буруугаар тайлбарлаж олон нийтийн дунд ихээхэн сөрөг үнэлэмжийг бий болгожээ. Ерөөсөө "Шар хэвлэл" хэмээх ойлголтыг сөргөөр ойлгуулахад улс төрчид онцгой үүрэг гүйцэтгэсэн юм.

Тэдний бузар булай, хээл хахууль авилгал гээд хийдэг бүхэн нь сонины байнгын зочин болохоор яаж ч сайн хандах билээ. Өөрсдийнх нь тухай үнэнийг бичээд байхаар түүнийг "худал" болгох гэж улайрдаг улс төрчид чөлөөт хэвлэлийг гүжирддэг, гүтгэдэг, худлаа залдаг мэтээр тойрон хүрээлэгчдээсээ эхлээд олон түмэнд ойлгуулах гэж махаа иддэг. Энэ байр сууриа баталгаажуулахдаа мэргэжлийн сэтгүүлчдийг, чөлөөт хэвлэлийг үгүйсгэж "шар"-аар нь цоллож иржээ. Тиймээс "Шар хэвлэл үүссэн цагаасаа ер сайн юм бүтээж байсан нь үгүй"¹⁹ хэмээх дүгнэлтүүдийг зоригтой өгч байв. Үнэн хэрэгтээ дэлхийн хамгийн анхны "шар" гэгдэх хэвлэлүүд болох Ж.Пулицерийн "The New York World" сонин төмөр замын магнат Ж.Шарпын хээл хахуулийн хэргийг сөхөж, гангийн үйлдвэрийн эзэн Ж.Морганы бондын луйварыг илчилсэнээрээ алдаршиж байсан бол У.Хёрстын "The morninng Journal"-ийнхан Нью-Йоркийн хийн трест, Үндэсний сахарын синдикат зэрэг монопольт байгууллагуудын булхайг илчилж "Оливеттын хэрэг", "Руисийн хэрэг", "Сиснерсорсын хэрэг", "Де Ломегиний хэрэг", "Мэйнийн хэрэг" гэх мэт зохион байгуулалттай зүйлсийг нийтлэн өөрийн байр сууриа баталгаажуулж байв. Эдгээрийн зарим нь зохиомол зүйл байсан ч зарим нь улс орны эдийн засагт төдийгүй үндэсний аюулгүй байдалд ч хор учруулж болох зүйлийг олж нийтлэн сэрэмжлүүлж байсан юм. Үүнтэй нэгэн адил монголын чөлөөт

хэвлэлүүд анх "Гаалийн хэрэг", "Баатарын хэрэг", "Аалзны тор", "Хадгаламж зээлийн хоршоодын хэрэг", "Зөөлөн эх"-ийн хэрэг гэх мэтийг илэрүүлэн мэдээлж байсан. Бид хэвлэлүүдээс л энэ тухай мэдээлэл авч байсан. Хожим нь бүгд үнэн болж батлагдан шүүх цагдаадаа тулсан.

Анхны "Шар хүүхэд"-ийн цувралыг гаргасан Ж.Пулицерийн "The New York World" сонин бол тухайн үеийн хэвлэлийн өнгө төрхийг бүрэн илэрхийлэгч төдийгүй Америкийн сэтгүүл зүйд гарсан бүх л өөрчлөлтийн эх суурийг тавьсан юм. Энгийн англи хэл, шог хошин зураг, сонины сенсааци зэрэг нь уншигчдын хүрээг тэлэх, англи хэл муутай цагаачдыг татахад

чухал нөлөө үзүүлсэн. Ж.Пулицер энэ сониноороо дамжуулан эрх мэдэлтнүүдийн үйл ажиллагаанд хяналт тавихыг зорьж байв. Энэ алхам нь олон нийтэд таалагдаж сониных нь хэвлэгдэх хувь хэмжээ ч өслөө. 1884 оны есдүгээр сард Ж.Пулицерийн алдарт "The New York World"-ын хэвлэгдэх хувь зуун мянга хүрхэд зуун их буугаар ёслолын буудлага хийж, бүх ажилтнууддаа өндөр торгон бортгон малгай бэлгэлсэн юм. Харин 1886 он гэхэд энэ сониных нь хэвлэгдэх хувь хоёр зуун тавин мянга

хүрхэд цэвэр мөнгөөр медаль хийлгэж бүх сэтгүүлчид, редактор, харилцагчид, реклам нийлүүлэгчиддээ гардуулж ямархан амжилт хүрсэнээ рекламдахаа мартаагүй юм.

"The New York World" томчуудын хэрэглээний зардлыг багасгах, татварын мөнгийг юунд зарцуулж байгааг шууд тайлагнах, ард түмний нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх шаардлагуудыг дугаар бүртээ тавьж эхлэв. Хэвлэлийн

хаан ажиллах арга барилаа "эхлээд ард түмний эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санаа бодолд тулгуурлах, дараа нь эрх мэдэлтнүүдийг шүүмжлэх" гэсэн зарчимд тулгуурлаж байлаа. Түүний сэтгүүлчид сенсаацитай мэдээлэл олж авахын тулд шоронд

«

Түүний сэтгүүлчид сенсаацитай мэдээлэл олж авахын тулд шоронд орж, галзуугийн эмнэлэгт хэвтэж, тагнах, чагнах үйл ажиллагаа явуулж, зүсээ хувиргах, хүнд хайр сэтгэлтэй болох, мөнгө өгөх зэргээр хэний ч олж чадахгүй мэдээллийг олж дөнгөдөг. Хамгийн дуулиантай мэдээллийг хамгийн түрүүнд олно.

»

орж, галзуугийн эмнэлэгт хэвтэж, тагнах, чагнах үйл ажиллагаа явуулж, зүсээ хувиргах, хүнд хайр сэтгэлтэй болох, мөнгө өгөх зэргээр хэний ч олж чадахгүй мэдээллийг олж дөнгөдөг. Хамгийн дуулиантай мэдээллийг хамгийн түрүүнд олно. Америкийн сэтгүүлчид тагнуулын төв газрыхнаас түрүүлж мэдээлэл олж авдаг гэсэн үнэлэмжийн эх суурийг тэрээр ингэж тавьсан юм. Тэр сэтгүүл зүйд ингэж хувьсал хийлээ. Өөрийн эрхэлдэг ажилдаа ямархан зүйлийг мөрдлөгө болгодог байсан нь түүний

редакцийн хананд хадаастай байдаг "Оновчтой, товч, тод томруун" гэсэн урианаас харж болно. Сурвалжлагчид даа "анхаарал татахуйц, өвөрмөц, эмгэнэлтэй, аймшигтай, ер бусын романтик бүхнийг олж уншигчийг бүдүүлэг үг хэллэгээр айлгалгүй хүргэж" байхыг сургасан юм. Түүний "Шар"-аараа цоллуулсан "The New York World" ард түмний эрх ашгийг жинхэнэ утгаар нь илэрхийлэгч болов. Өөрөө ч тэгж тунхаглаж байлаа. Одоо "Шар сэтгүүл зүй"-г хэрэгжүүлсэн "The New York World"-ын тухай ном хэвлэгдэн гарч барууны сэтгүүл зүйн салбарт судлагдсаар байна.

1890 онд өөрийн сониноо Нью-Йоркийн хамгийн өндөр барилгад офисстой болгосон, сэтгүүл зүйн сургууль байгуулахад зориулан мөнгө хандивласан, сэтгүүлчдийн боловсролд анхаарсан, тэднийг шагнах санг санаачилсан, ажилчдынхаа нийгмийн асуудлуудыг шийдвэрлэсэн, хэвлэлийн техник технологийн хөгжилд анхаарч байсан, хямд өртөгтэй олон хувиар хэвлэгддэг сониныг бий болгосон, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлсэн, шинэ сэтгүүл зүйг үндэслэсэн, дөрөвдэх засаглалыг анх удаа хэрэгжүүлсэн гээд Ж.Пулицерийн энэ салбарынхны төлөө хийсэн зүйлүүдийг нь тоочоод байж болно. Бас ард түмний эрх ашгийг ямагт хамгаалж, нийгмийн хамгааллын олон арга хэмжээг зохион байгуулж Бруклинг Манхеттэнтэй холбосон гүүрийг бариулсан, Америкийн эрх чөлөөний хөшөөг босгосон хүртлээ

олон компанид ажлуудыг удирдан явуулж байв.

Ж. Пулицерийн үндэслэж, У.Хёрстийн мөнхжүүлсэн "Шар сонин" бол олон нийтэд зориулсан, хямд төсөр, тэдний эрх ашгийг хамгаалагч хэвлэл болно. Бас олон хувиар хэвлэгдэж нийт ард түмний хүсэмжилж буй мэдээ, мэдээллийг нийтэлхийг чухалчилдаг. Цөөнхийн үйл ажиллагаанд хяналт тавьж засаглалыг хэрэгжүүлэхийг эрмэлдэг онцлогтой. Эрх мэдэлтнүүдийн мэдээ, мэдээллийг онцолж үйл ажиллагаанд нь олонхийн байр сууринаас шүүмжлэлттэй ханддаг. Энэ байдал нь эрх мэдэлтэн, цөөнхүүдэд таалагддаггүй учир "шар"-аараа дуудуулж түүхэнд мөрхөрчээ. Тиймээс "Шар сонин"-г олонхийн эрх ашгийн үүднээс авч үзвэл "сайн хэвлэл", цөөнхийн байр сууринаас дүгнэвэл "муу хэвлэл" болно.

Ишлэл

¹ З у л ь к а ф и л ь М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.

² Залуу удирдагч 2000. Бат-Үүл Э. Шар хэвлэлийг "устгах" миний төлөвлөгөө. УБ.

³ Ч о й с а м б а Ч. 2003. Дэлхийн сэтгүүл зүйн түүх. 1609-1900 он. УБ., 147 дахь тал.

⁴ "New York World" сонин. 1896.4.12. Зураач Р.Ауткаульт.

⁵ "New York World" сонин. 1896.3.22. Зураач Р.Ауткаульт.

⁶ "New York World" сонин. 1896.1.5. Зураач Р.Ауткаульт.

⁷ "New York World" сонин. 1895. 5.5. Зураач Р.Ауткаулт

⁸ "New York World" сонин. 1896. 5.3. Зураач Р.Ауткаулт.

⁹ "New York World" сонин. 1896.5.17. Зураач Р.Ауткаулт.

¹⁰ "New York World" сонин. 1896.5.24. Зураач Р.Ауткаулт.

¹¹ "New York World" сонин. 1896.6.7. Зураач Р.Ауткаулт.

¹² "New York World" сонин. 1896.6.28. Зураач Р.Ауткаулт.

¹³ "New York World" сонин. 1896.7.5. Зураач Р.Ауткаулт.

¹⁴ "New York World" сонин. 1896.7.12. Зураач Р.Ауткаулт.

¹⁵ "New York World" сонин. 1896.7.19. Зураач Р.Ауткаулт.

¹⁶ "New York World" сонин. 1896.7.26. Зураач Р.Ауткаулт.

¹⁷ "New York Journal" сонин. 1896.10.25. Зураач Р.Ауткаулт.

¹⁸ "New York Journal" сонин. 1898.1.23. Зураач Р.Ауткаулт.

¹⁹ Залуу удирдагч 2000. Бат-Үүл Э. Шар хэвлэлийг "устгах" миний төлөвлөгөө. УБ. 141 дэх тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. <http://almostheaven.blogspot.com/2005/08/cidado-kane.html>
2. <http://almostheaven.blogspot.com/2005/08/cidado-kane.html>
3. http://www.dyslexiamentor.com/famous/famousdyslexics_020.php

4. http://www.worldpaper.com/archive/2003/june_12

5. <http://www.moviemeter.nl/?film=1612>

6. <http://motulz.multiply.com/journal/item/5>

7. <http://www.zigurraat.altervista.org/manga/hcom.htm>

8. <http://www.ihousephilly.org/pennarchive2005.htm>

9. <http://xroads.virginia.edu/~MA04/wood/ykid/newsprint.htm>

10. <http://xroads.virginia.edu/~MA04/wood/ykid/newsprint.htm>

11. <http://www.Kids.Net.Au>

12. <http://www.neponset.com/yellowkid/>

13. <http://www.ebay.com>>

14. <http://www.neponset.com/yellowkid/>>

15. <http://www.pulitzer.org/history.html#bio>

16. Г а л д а н Т. 2002. Олон улсын сэтгүүл зүйн түүхийн хураангуй тойм. УБ.

17. Б а а б а р Б. Чөлөөт хэвлэл ба түүний дайснууд. www.baabar.net.

18. Б а а б а р Б. Сэтгэхүйн хөх толбо. //Гурван монгол зодолдоно. УБ. 2005.

19. Б а я р т о г т о х М. 2003. Дэлхийн сэтгүүл зүйн түүхийн тойм. УБ.

20. Б а т - Ү ү л Э. 1996. "Шар хэвлэлийг "устгах" миний төлөвлөгөө." УБ.

21. В о р о ш и л о в В. В. 2001. Дэлхийн сэтгүүл зүйн түүхээс. (Орч. Ш.Одонтер, С.Амартүвшин), УБ.

22. З у л ь к а ф и л ь М. 2003. Дэлхийн сэтгүүл зүйн түүх. XX зуун. УБ.

23. Ч о й с а м б а Ч. 2003. Дэлхийн сэтгүүл зүйн түүх. 1609-1900 он. УБ.